

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2023/18/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Даланзадгад хот  
2023 он

Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn  
Ахлах аудитор: Ж.Болормаа  
Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:  
Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК  
Утас:99099119 Цахим хаяг:gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал .....	Error! Bookmark not defined.
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	4
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	8
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	10
4.1 Ерөнхий зүйл .....	10
4.2 Материаллаг байдал .....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
4.5.1 Завсрын аудитын талаар.....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	12
5.1 Төлбөрийн акт .....	13
5.2 Албан шаардлага .....	13
5.3 Зөвлөмж .....	13
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 48063  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.09.20 № 251

таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ  
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.ЭРДЭНЭТӨГС ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Эрчим хүчний сайдын 2022 оны А/124 дугаар тушаалаар төлөвлөгөөнд тодотгол хийгдсэн дагуу 17.6 сая кВт.ц цахилгаан эрчим хүч боловсруулахаас 10.5 сая кВт.ц цахилгаан эрчим хүч боловсруулан боловсруулалтын төлөвлөгөөг 59.6 % түгээлтийн төлөвлөгөөг 45.2 % тай биелүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зуухны их засварын ажлыг 1,842.7 сая, сумын төвийн дулааны болон цэврийн шугам сүлжээг өргөтгөж шинээр барих ажлыг 1,200.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн байна.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016020357

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	15,484,348.95	53,843,932.37
1.1.2	Дансны авлага	545,500,990.08	399,556,016.49
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	4,749,119.19
1.1.6	Бараа материал	479,331,027.06	680,871,752.75
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	866,313,223.94	1,469,660,905.45
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,906,629,590.03</b>	<b>2,608,681,726.25</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	7,430,786,152.33	9,396,693,935.99
1.2.2	Биет бус хөрөнгө	1,676,393,551.02	1,676,251,551.02
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	307,225,389.52	294,240,332.07
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>9,414,405,092.87</b>	<b>11,367,185,819.08</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,321,034,682.90</b>	<b>13,975,867,545.33</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,262,473,834.86	1,947,609,666.44
2.1.1.2	Цалингийн өглөг	3,446,821.56	5,044,505.20
2.1.1.3	Татварын өр	1,933,259,497.87	2,404,167,992.41
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,655,611,957.21	1,957,401,801.34
2.1.1.5	Богино хугацаат зээл	5,313,095,514.24	5,179,032,487.05
2.1.1.6	Хүүний өглөг	1,147,043,279.18	1,158,667,963.29
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	958,398,882.12	881,668,327.31
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	172,918,713.33	744,306,542.88
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>12,446,248,500.37</b>	<b>14,277,899,286.05</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	3,051,418,612.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	356,654,135.00	356,654,135.00
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>356,654,135.00</b>	<b>3,408,072,747.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>12,802,902,635.37</b>	<b>17,685,972,033.05</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	8,337,595,020.45	8,337,595,020.45
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,808,076,252.49	4,808,076,252.49
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,655,056,500.00	1,655,056,500.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(16,282,595,725.27)	(18,510,832,260.66)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>(1,481,867,952.33)</b>	<b>(3,710,104,487.72)</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11,321,034,683.04</b>	<b>13,975,867,545.33</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>5,295,557,632.18</b>	<b>4,076,588,389.32</b>
<b>2</b>	<b>Борлуулалтын өртөг</b>	<b>7,609,385,895.87</b>	<b>6,795,559,457.00</b>

<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	(2,313,828,263.69)	(2,718,971,067.68)
8	Бусад орлого	1,871,975,591.40	2,552,018,392.78
9	Борлуулалт, маркетингийн зардал		1,565,699.09
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,055,455,795.40	1,131,851,383.93
11	Санхүүгийн зардал		11,624,684.11
12	Бусад зардал	77,265,490.87	916,780,697.70
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(929.06)	538,604.34
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2,087,990,765.99)	(2,228,236,535.39)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,087,990,765.99)	(2,228,236,535.39)
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	(2,087,990,765.99)	(2,228,236,535.39)
24	Орлогын нийт дүн	(2,087,990,765.99)	(2,228,236,535.39)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	8,337,595,020.45	4,808,076,252.49	1,655,056,500.00	(14,194,604,959.28)	606,122,813.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-		
<b>Залруулсан үлдэгдэл</b>	8,337,595,020.45	4,808,076,252.49	1,655,056,500.00	(14,194,604,959.28)	606,122,813.66
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(2,087,990,765.99)	(2,087,990,765.99)
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	8,337,595,020.45	4,808,076,252.49	1,655,056,500.00	(16,282,595,725.27)	(1,481,867,952.33)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	0.00	0.00
<b>Залруулсан үлдэгдэл</b>	8,337,595,020.45	4,808,076,252.49	1,655,056,500.00	(16,282,595,725.27)	(1,481,867,952.33)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(2,228,236,535.39)	(2,228,236,535.39)
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	8,337,595,020.45	4,808,076,252.49	1,655,056,500.00	(18,510,832,260.66)	(3,710,104,487.72)

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,717,870,589.39	7,684,878,369.74
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,943,387,116.70	4,922,993,441.46
	Татаас, санхүүжилтийн орлого	1,573,554,700.00	2,395,000,000.00
	Бусад мөнгөн орлого	200,928,772.69	366,884,928.28
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,593,402,277.66	7,442,774,014.30
	Ажиллагчдад төлсөн	3,329,695,711.66	3,069,039,340.63
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	470,000,000.00	553,794,809.22
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,853,574,632.46	1,832,175,832.95
	Ашиглалтын зардалд төлсөн	96,082,775.29	151,554,946.09
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	842,496,365.52	1,150,865,246.34
	Хүүний төлбөрт төлсөн	20,286,647.00	20,808,557.38
	Татварын байгууллагад төлсөн	373,767,271.65	207,942,351.75
	Даатгалын төлбөрт төлсөн	3,870,000.00	6,394,750.00
	Бусад мөнгөн зарлага	603,628,874.08	450,198,179.94
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>124,468,311.73</b>	<b>242,104,355.44</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	168,358,504.25	51,235,900.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	168,358,504.25	35,383,900.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	15,852,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(168,358,504.25)</b>	<b>(51,235,900.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,382,512,131.09	1,685,030,200.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,382,512,131.09	1,685,030,200.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,352,020,759.22	1,838,077,676.36
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,352,020,759.22	1,838,077,676.36
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>30,491,371.87</b>	<b>(153,047,476.36)</b>
<b>4.1</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>(929.06)</b>	<b>538,604.34</b>
<b>4.2</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(13,399,749.71)</b>	<b>38,359,583.42</b>
<b>5.1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>28,884,098.66</b>	<b>15,484,348.95</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны төлөвлөгөө	2022 оны гүйцэтгэл	Харьцуулалт	Хувь	
1	Боловсоруулсан	ЦЭХ	мян.кВт.ц	17,564.4	10,504.8	(7,059.6)	59.8
		ДЭХ	Мян.Гкал	85.6	75.0	(10.6)	87.6
	Дотоод хэрэгцээ	Хувиар	хувь	34.4	47.2	12.8	137.2
		Биетээр	мян.кВт.ц	6,037.8	4,956.0	(1,081.8)	82.1
	Эрчим хүч түгээлт	ЦЭХ	мян.кВт.ц	11,527.6	5,150.6	(6,377.0)	44.7
		ДЭХ	Мян.Гкал	83.5	72.9	(10.6)	87.3
2	Нийт орлого	сая.төг	6,887.3	6,629.1	(258.2)	96.3	

		Үйл ажиллагааны орлого	сая.төг	4,745.3	4,076.6	(668.7)	85.9
	Үүнээс:	Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	142.0	375.2	233.2	264.2
		Санхүүжилт	сая.төг	2,000.0	2,177.3	177.3	108.9
	Нийт зардал		сая.төг	9,357.2	8,857.4	(499.8)	94.7
3	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	8,840.6	8,337.5	(503.1)	94.3
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	516.6	519.9	3.3	100.6
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал		сая.төг	1,245.3	1,105.6	(139.7)	88.8
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая.төг	(2,469.9)	(2,228.3)	241.6	90.2
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая.төг	(2,469.9)	(2,228.3)	241.6	90.2
6	БО-ын 1 төгрөгт ногдох зардал		төг	1.97	2.17	0.2	110.2
	Нийт авлага		сая.төг	400.2	404.3	4.1	101.0
7	Үүнээс:	ЭХ-ний	сая.төг	72.5	94.7	22.2	130.6
		Бусад	сая.төг	327.7	309.6	(18.1)	94.5
	Нийт өглөг		сая.төг	12,500.0	17,686.0	5,186.0	141.5
8	Үүнээс:	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	356.7	3,408.1	3,051.4	955.5
		Богино хугацаат өр төлбөр	сая.төг	12,143.3	14,277.9	2,134.6	117.6
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	176	176	-	100.0
10	Нийт цалингийн сан		сая.төг	4,188.9	3,021.5	(1,167.4)	72.1
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	Цахилгаанд	гр/квтц	1,317.7	1,513.3	195.6	114.8
		Дулаанд	кг/гкалц	234.2	252.7	18.5	107.9
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая.төг	797.5	670.9	(126.6)	84.1

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК нь “Хэмнэлтийг эрхэмлэн инноваци шингэсэн эрчим хүчээр хэрэглэгчдийг найдвартай хангана” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах
- Цахилгааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах

#### 3.2 ТӨХК-ийн гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Эрчим хүчний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.



Тайлант хугацаанд ТӨХК-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдан 2022 оны 5 сараас зарим заалтууд нь хэрэгжиж эхэлсэн байна.

ТӨХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тайлант онд тус байгууллагад дотоод аудиторын орон тоо батлагдаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын удирдлагын тушаалаар 2022 онд батлуулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх ноос 2,654.8 сая төгрөгөөр буюу 23.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15,484.3	53,843.9	38,359.6
Авлага	1,411,814.2	1,873,966.0	462,151.8
Бараа материал	479,331.0	680,871.8	201,540.8
Үндсэн хөрөнгө	9,414,405.1	11,367,185.8	1,952,780.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>11,321,034.6</b>	<b>13,975,867.5</b>	<b>2,654,832.9</b>
Өр төлбөр	12,802,902.6	17,685,972.0	4,883,069.4

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-1,481,868.0	-3,710,104.5	-2,228,236.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>11,321,034.6</b>	<b>13,975,867.5</b>	<b>2,654,832.9</b>

Дээрх хүснэгтээс харахад Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данснууд байна. Авлага өсөх болсон шалтгаан нь хөрөнгө оруулалтаар хийгдсэн гэрээт ажлын төлбөрийг олгоод урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлжээ. Бараа материал дансны үлдэгдэл 201.5 сая төгрөгөөр өсөхөд нүүрсний үлдэгдэл 95.4 сая, сэлбэг хэрэгсэл 71.1 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлжээ. Үндсэн хөрөнгө данс өсөх болсон шалтгаан нь тайланд онд үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасантай, өр төлбөр өсөх болсон шалтгаан нь үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг хойшлогдсон орлогоор бүртгэсэн, цахилгаан үйлдвэрлэл багассантай холбоотойгоор Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д 430.7 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн, татаас санхүүжилтээс нэмэгдсэн өртгийн албан татвар авдаг болсонтой холбоотойгоор 339.8 сая, Нийгмийн даатгалын шимтгэлийг өглөг 301.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК нь техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2022 оны А/222 тоот тушаалаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 6,887.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 9,357.2 сая төгрөгөөр, 2,469.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 6,629.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 8,857.4 сая төгрөгийн зардал гарган, 2,228.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 6,629.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 258.2 сая төгрөг буюу 3.7 хувиар тасарсан нь цахилгааны эрчим хүчний түгээлт 50 хувиар буурсантай холбоотойгоор цахилгаанаас олох орлого буурснаас шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 8,857.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 499.9 сая төгрөг буюу 5 хувиар хэмнэсэн нь урсгал засвар, цалингийн зардлыг хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд 797.5 сая төгрөгийг баталжээ. Гүйцэтгэлээр 670.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал гаргаж 126.6 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Тайлант онд алдагдал нь 2,228.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 241.6 сая төгрөгөөр дутуу байгаа нь нь тайлант онд зардал хэмнэсэн нь нөлөөлжээ.

Орон нутгийн өмчийн газарт тайлант онд ногдол ашгийн, түрээсийн орлогыг төвлөрүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ТӨХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулахаар бүтэц орон тоотой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ын аудитор Д.Мөнхтулга гүйцэтгэж анхан шатны чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Ж.Ням—Осор, хоёр дахь шатны хяналтыг захирал Д.Баатарсайхан хэрэгжүүлнэ. Чанарын хяналтыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа, аудитын менежер Т.Хонгорзул дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК нь 2022 оны санхүүгийн тайлангаа Өмнөговь аймгийн дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын сарын 09-ны өдрийн 01/84 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын тайлангийн нийт зардлын 8,055.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 80.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 60.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж зардлыг гаргахгүй байх зэргээр зорилтот түвшний хүрээнд батлагдсан зардлыг хэмнэж ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цалин хөлс, нийгмийн даатгалын зардлыг 91.0 сая, урсгал засварын зардлыг 260.0 сая төгрөгөөр хэмнэжээ.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 173 мэдээлэл мэдээлэхээс бүх мэдээллийг хуулийн хүрээнд хугацаанд нь бүрэн байршуулсан байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-иас Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны III улирлын санхүүгийн тайланд завсрын аудитыг хийсэн байна. Завсрын аудитаар 75.1 сая төгрөгийн 2 албан шаардлага, 25.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 55.8 сая төгрөгийн 3 албан шаардлага, 4 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Өмнөх аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилган өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,500.0	1	1,500.0	100
Албан шаардлага	3	55,863.7	3	55,863.7	100
Зөвлөмж	4	0	4	0	100
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>57,363.7</b>	<b>8</b>	<b>57,363.7</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нүүрс зарцуулалтын тооцоог хянах шаардлагатай байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25.4 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 25.4 сая төгрөгийн 1 алдааг залрууллаа.

Үүнд Ширэм хайлуулах үйлдвэрийг данс бүртгэлд тусгаагүй байсныг залруулж үндсэн хөрөнгө дансанд бүртгэлээ.

Аудитаар нийт 93.2 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 93.2 сая төгрөгийн 3 албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмж өгөгдлөө.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## **5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт бичигдээгүй болно.

## **5.2 Албан шаардлага**

5.2.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд байгууллагын төсвөөс 18.1 сая төгрөгийг томилолт болон бусад үйл ажиллагаанд зарцуулжээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.2.3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн тэвчиж болох зардлыг хэмнэн ажиллах албан шаардлага бичигдлээ.

5.2.2 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлант хугацаанд 75.1 сая төгрөгийн хөрөнгийг эхэлж худалдан аваад дараа нь худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдийн чадавхын шалгуур үзүүлэлт, түүнд тавигдах шаардлага, тэдгээрийг хангасныг нотлох баримтыг тусгасан урьдчилсан сонголтын баримт бичгийг бэлтгэх”, 13.1.2-д “урьдчилсан сонголт явуулах тухайгаа энэ хуулийн 21.1, 21.4-т заасны дагуу зарлан мэдээлэх”, 13.1.3-д “урьдчилсан сонголтын баримт бичигт заасан чадавхын шалгуур үзүүлэлтийг хангасан оролцогчид тендер ирүүлэхийг мэдэгдэх” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтлан ажиллаж хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах албан шаардлага бичигдлээ.

5.2.3 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь 2022 онд нүүрс тээврийн үйл ажиллагаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Шалгарсан этгээдээр нүүрс тээвэрлүүлэх гэрээг байгуулсан ч өр төлбөрийн асуудлаас болж 10, 11, 12 саруудад иргэдтэй гэрээ байгуулан нүүрс тээврийг хийлгэсэн байна.

Энэ нь Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-д нүүрс тээврийн үйлчилгээ үзүүлэх (ДзДЦС/202201012) №22/52 тоот гэрээний 2.4-д “Гүйцэтгэгч нь тухайн сард тээвэрлэх нүүрсийг бүрэн тээвэрлэн дуусган тооцоо хийсэн тохиолдолд захиалагч дараа сарын 15-ны дотор тээврийн хөлсийг төлнө” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаанд оролцож шалгарсан аж ахуйн нэгжээр нүүрс тээврийг хийлгэн гэрээний үүргээ биелүүлэн ажиллах албан шаардлага бичигдлээ.

## **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Батлагдсан бүтэц орон тоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын 2022 оны бүтэц, орон тоог Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан байна. Байгууллагын

даргын 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/61 тоот тушаалаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бүтцийг өөрчилсөн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18-д “энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал”, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.4-д “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах” гэсэн заалттай нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын бүтэц, орон тоог компанийн дүрэмд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө батлуулан мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгийг дутуу бүртгэсэн	1	25,409.9			1	18,107.4	1	18,107.4				
Дүн	1	18,107.4			1	18,107.4	1	18,107.4				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТУЗ-ын шийдвэргүйгээр бүтэц баталсан	1						1					
Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй	1				1							
Дүн	2				1		1					

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Хуулиар хориглосон арга хэмжээг санхүүжүүлсэн	1	18,107.4			1	18,107.4				

Дүн	1	18,107.4			1	18,107.4		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	75,104.4			1	75,104.4		
Дүн	1	75,104.4			1	75,104.4		
Нийт дүн	2	93,211.8			2	93,211.8		



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 190/1650359

Даланзадгад сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 2022 онд нүүрс тээврийн үйл ажиллагаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчээр шалгарсан этгээдээр нүүрс тээвэрлүүлэх гэрээг байгуулсан ч өр төлбөрийн асуудлаас болж 10, 11, 12 саруудад өргөдтэй шууд гэрээ байгуулан нүүрс тээврийг хийлгэсэн байна.

Энэ нь Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-д нүүрс тээврийн үйлчилгээ үзүүлэх (ДэДЦС/202201012) №22/52 тоот гэрээний 2.4 "Гүйцэтгэл нь тухайн сард тээвэрлэх нүүрсийг бүрэн тээвэрлэн дуусган тооцоо хийсэн тохиолдолд захиалагч дараа сарын 15-ны дотор тээврийн хөлсийг төлнө" -д заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй;" -д заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Худалдан авах ажиллагаанд оролдож шалгарсан аж ахуйн нэгжээр нүүрс тээврийг хийлгэн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллан биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 01-ны дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн захирал (Д.Эрдэнэтөгс) нягтлан бодогч (Ц.Хандцоо) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР  
АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.ӨСӨХБАЯР

Д.БААТАРСАЙХАН





ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 191/А1650359

Даланзадгад сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 75,104,437 төгрөгийн хөрөнгө худалдан авахаар шилжүүлэг хийсний дараа худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 "тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдийн чадавхын шалгуур үзүүлэлт, түүнд тавигдах шаардлага, тусгээрийг хангасныг нотлох баримтыг тусгасан урьдчилсан сонголтын баримт бичгийг бэлтгэх", 13.1.2 "урьдчилсан сонголт явуулах тухайгаа энэ хуулийн 21.1, 21.4-т заасны дагуу зарлан мэдээлэх", 13.1.3 "урьдчилсан сонголтын баримт бичигт заасан чадавхын шалгуур үзүүлэлтийг хангасан оролцогчид тендер ирүүлэхийг мэдэгдэх" дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журмыг баримтлаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3 дахь заалтуудыг хэрэгжүүлэн биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 02-ны дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх,

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн захирал (Д.Эрдэнэтөгс), нягтлан бодогч (Ц.Хандцоо) нар даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГЭГЛЭХ АУДИТОР

ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР  
АУДИТ ТӨХК -ИЙН ЗАХИРАЛ

Ц.ӨСӨХБАЯР

Д.БААТАРСАЙХАН

D:\2023\Зон\Явсан Бичиг\Албан шаардлага\2023.03.15 Doc

016040584



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 192/01650359

Даланзадгад сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэлгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын хөрөнгөөр Эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулж 18,107,428 төгрөгийг томилолт болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж бичиг хэрэг, тээвэр шатлуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаг зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 095 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэх заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 02-ны дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн захирал (Д.Эрдэнэтөгс), нягтлан бодогч (Ц.Хандцоо) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭГГҮҮЛЭХ АУДИТОР

ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР  
АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.ӨСӨХБАЯР

Д.БААТАРСАЙХАН

D:\2023он\Явсан Бичиг\Албан шаардлага\2023.03.15 Дос

016040587

